



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04 сарын 17-ны өдрийн 14:00 цагт ХУД, 3-р хороонд байрлах Төв дэлгүүрийн дэргэдэх Мираж гэр ресторанд болов. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, Б.Нандин-Эрдэнэ, З.Шагдарсүрэн, ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг, Ц.Баатарсайхан, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа нар панелистаар оролцов.

ХУРЛЫН ИРЦ:

Тооллогын комиссын дарга Ч.Солонго бүртгэлийн өдрөөр “Говь” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 7,801,125 байгаагаас 6,946,873 саналын эрхтэй, нийт 210 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 89.05% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасан тул хурлын дарга хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

ХУРЛЫН ДЭГ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх

/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/

2. Тооллогын комисс болон редакцын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах

/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/

3. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавих:

- 3.1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах

/Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа/

- 3.2. ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах

/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/

- 3.3. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн тухай дүрмийн төслийг танилцуулах

/Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр/

- 3.4. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах

/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/

3.5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга

/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/

3.6. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулах

/ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дарга Д.Гэрэлмаа/

4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт
5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл
6. Саналын хуудсаар санал авах
7. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах
8. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал асуулгын дүнг тусган редакцын комиссын дарга танилцуулж төслийг батлуулах

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

1. Хурлын дарга Д.Гэрэлмаа хурлыг нээж, хурлын дэгийн дагуу илтгэлүүдийг эхлүүлэв.

2. ХЭЛЭЛЦСЭН нь:

Тооллогын комисс болон редакцын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Сайн байцгаана уу? ТУЗ-өөс Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс болон редакцын комиссыг томилсон. Тооллогын комиссын даргаар Захиргаа, хүний нөөцийн газрын захирал Ч.Солонго, нарийн бичгийн даргаар Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга М.Болортуяа, гишүүдээр Ахлах нягтлан бодогч Ц.Цэцэгбадам, Санхүү бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Г.Золзаяа, Хүний нөөцийн хэлтсийн менежер З.Золжаргал, мэдээлэл технологийн инженер П.Төгсжаргал нарыг томилсон байгаа. Редакцын комиссын даргаар “Говь” ХК-ийн Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр, гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ-г тус тус томилсон.

Тооллогын комисс нь хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэн мэдээлэл өгөх, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах үүрэгтэй. Редакцын комисс нь тооллогын комиссын санал хураалтын дүнд үндэслэн хурлаас гарах тогтоолын төслийг боловсруулж батлуулна.

3.1 ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа танилцуулав.

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Говь” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны тайланг товчхон танилцуулъя. Та бүхэнд тараасан жилийн тайланд бүх мэдээллүүд багтсан байгаа. Үүнээс гол гол тоо баримтууд болон онцлох үйл явдлуудыг товч

танилцуулъя. Танилцуулгатай холбоотой асууж тодруулах зүйл байвал хуваарийн дагуу асуулт хариултын цагт асууна уу.

2017 оны санхүүгийн гол тоон үзүүлэлтийг инфографик байдлаар харуулсан байгаа.

- Борлуулалтын орлого нийт 124.4 тэрбум төгрөг байсан ба 2016 оноос 40%-ийн өсөлттэй, үүнд дотоод борлуулалт 38%-иар, гадаад борлуулалт 44%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийт цэвэр ашиг 17.5 тэрбум төгрөг болж 2016 оноос 8%-иар өссөн байна.
- Нийт төсөвт төлсөн татвар хураамж 20 тэрбум төгрөг буюу 2016 оноос 45%-ийн өсөлттэй байна.
- 2016 оны 12-р сарын байдлаар компанийн үнэлгээ 181.4 тэрбум төгрөг болж 2016 оноос 129%-иар өссөн байна.
- 2017 оны түүхий эд бэлтгэл 2016 оноос 54%-ийн өсөлттэй. Нийт ажилтнуудын тоо 8% буюу 124 ажилтнаар нэмэгдсэн.

Түүхий эд бэлтгэлтэй холбоотой мэдээлэл:

- Түүхий эд бэлтгэл 2017 онд нийт 743 тонн ноолуур бэлтгэж үйлдвэрлэлээ явуулж борлуулалтаа хийсэн бол 2018 оны хувьд бизнес төлөвлөгөөгөөр 850 тонн түүхий эд авахаар төлөвлөсөн. 2017 оны онцлог нь угаасны дараа самнах дамжлагын хүчин чадлаа нэмэгдүүлсэн байгаа. Улмаар 2018 онд бэлтгэх 850 тонн түүхий эдээ 100% дотооддоо самнаж хагас боловсруулалт хийх боломжтой болоод байна.

Хөрөнгө оруулалттай холбоотой мэдээлэл:

- 2017 онд нийт 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 3.3 тэрбум төгрөгийг үйлдвэрийн өргөтгөл хийх, 7.4 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж нэмэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зарцуулсан.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд ээрмэл утасны үйлдвэрлэл 352 тонн болж 23%-иар өссөн, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 567 мянга буюу 9%-иар өссөн бол нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл 432 мянган метр болж 2016 оноос 50%-иар өссөн байна. Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэл 57 мянган ширхэг буюу 2016 оноос 2.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулалттай холбоотой мэдээлэл:

- Гадаад зах зээлийн хувьд Говь ХК-ийн нэрийн дэлгүүр 4, франчайзинг дэлгүүр 6 буюу нийт 10 дэлгүүр шинээр нээсэн. Ингэснээрээ дэлхийн 13 улсад 55 нэрийн болон франчайзинг дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.
- Борлуулж байгаа бүтээгдэхүүнийг нэр төрөл тус бүрээр задалж үзвэл 2015 он хүртэл оёмол бүтээгдэхүүн буюу ноолууран пальтоны борлуулалтаас илүү ихэвчлэн сүлжмэл болон нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулдаг байсан бол 2015 оноос эхлэн 100% ноолууран пальтоны үйлдвэрлэл, борлуулалтад анхаарч ажиллаж эхэлсэн. 2016 оноос эхлэн нийт борлуулалтын 59%-ийг сүлжмэл бүтээгдэхүүн, 23%-ийг нэхмэл бүтээгдэхүүн, 15%-ийг оёмол бүтээгдэхүүн эзэлж байсан бол 2017 онд нийт

борлуулалтын 52%-ийг сүлжмэл бүтээгдэхүүн, 23%-ийг нэхмэл бүтээгдэхүүн, 23%-ийг оёмол бүтээгдэхүүн эзэлсэн. Цаашид 2018 онд нийт борлуулалтын 46%-ийг сүлжмэл бүтээгдэхүүн, 21%-ийг нэхмэл бүтээгдэхүүн, 31%-ийг оёмол бүтээгдэхүүн эзлэхээр төлөвлөж байна. 2018 онд пиджак болон пальтоны үйлдвэрлэл, борлуулалтад түлхүү анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

- Борлуулалттай холбоотой сонирхолтой мэдээллүүдээс дурдвал жилийн хамгийн өндөр борлуулалттай өдөр 2017 оны 08-р сарын 26-ны өдөр дотоодын нэрийн барааны дэлгүүрүүд нийлбэр дүнгээрээ нэг өдөрт 586.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн 2017 оны 11-р сарын 24, 25, 26-ны өдрүүдэд Black Friday хямдралаар 3 өдөрт 1.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Хамгийн өндөр пальтоны борлуулалт хийсэн өдөр 2017 оны 09-р сарын 17-ны өдөр 249 ширхэг пальто борлуулсан. Пальтоны хувьд зөвхөн дотоодын зах зээлд гэлтгүй гадаадын зах зээлд нэлээд танигдаад байна. Жишээлбэл БНСУ-ын TV shopping-оор 7 минутад 800 ширхэг ноолууран пальто зарагдаж дууссан бол 1,000 ширхэг ноолууран пальто 23 минутад зарагдсан нь Говь ХК-ийн бүтээгдэхүүн тэр дундаа ноолууран пальто ихээхэн танигдаж борлуулалт нь нэмэгдэж байгааг хэлэхэд таатай байна.

Онцлох үйл явдал:

- 2017 онд болсон бас нэгэн онцлох үйл явдал бол үйлдвэрийн дээвэр дээр гарсан галын аюул юм. 2017 оны 06-р сарын 14-ний өдөр үйлдвэрийн үндсэн хэсгийн зүүн хэсэгт дээврийн нөхөн засвар хийж байсан гүйцэтгэгч компани ил гал гаргаснаас болоод нийт үйлдвэрийн дээврийн 18,000 м² талбай галд өртсөн. Азаар хүний амь нас, эрүүл мэнд эрсдээгүй. Галыг 1 өдрийн дотор унтрааж 10 хоногийн дотор буюу 2017 оны 06-р сарын 24-ний өдөр гэхэд үйлдвэр эргээд хэвийн ажиллагаандаа орсон. Галын аюулаас үүдээд авсан гол арга хэмжээ нь компанийн хэмжээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг бүрэн шинэчилж Нийслэлийн онцгой байдлыг газраар батлуулсан. Мөн 2017 оны 11-р сарын 31-ний өдөр болон 2017 оны 12-р сарын 01-ний өдрүүдэд Хан-Уул дүүргийн ОБЕГ, Нийслэлийн гал унтраах баг бүрэлдэхүүнтэй хамтран Говь ХК-ийн гамшгаас хамгаалах комисс болон гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг нээж бүрэн хэмжээний гамшгаас хамгаалах үзүүлэх сургалтыг компани дээр зохион байгуулсан. Цаашид жил болгон тогтмол гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулж гамшиг ослын үед хамгийн бага хохиролтойгоор хамгийн хурдан хугацаанд ажиллах арга хэмжээг авч байгаа.

Төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж:

- Компанийн хувьд нийгэмд үзүүлэх хамгийн гол үр дүн бол төсөвт төвлөрүүлж байгаа татвар юм. Говь ХК-ийн хувьд 2017 онд улсын төсөвт нийт 20 тэрбум төгрөгийн татвар хураамжийг төлсөн. Ингэснээрээ улсын хэмжээнд топ 10 татвар төлөгч байгууллагад багтсан. Энэ нь эргээд уул уурхай, барилгын салбараас бусад буюу хөнгөн аж үйлдвэрийн салбараас анхны шилдэг татвар төлөгч болсон үйл явдал байлаа.

2018 оны бизнес төлөвлөгөөний тухай:

- 2018 оны хувьд компанийн ТУЗ-өөр батлуулсан бизнес төлөвлөгөөгөөр борлуулалтын орлогыг 150.4 тэрбум төгрөг буюу 2017 оноос 21%-ийн өсөлттэй тэр дундаа гадаад

борлуулалтыг 8%, дотоод борлуулалтыг 29%-иар өсгөхөөр тус тус төлөвлөсөн байгаа. Түүхий эд татан авалтыг 850 тонн буюу 2017 оноос 14%-иар өсгөх, ээрмэл утасны үйлдвэрлэлийг 407 тонн болгож 17%-иар өсгөх, нийт ажилтнуудын тоог 1,956 болгож 13%-иар өсгөх, нэхмэл бүтээгдэхүүнийг 480 мянган метр буюу 11%-иар өсгөх, сүлжмэл бүтээгдэхүүний тоо ширхгийг 800 мянган ширхэг болгож 41%-иар өсгөх, оёмол пальто, пиджакийг 69 мянган ширхэг болгож 69%-иар өсгөхөөр бизнес төлөвлөгөөг төлөвлөж батлуулсан.

2018 оны бизнес төлөвлөгөө болон 2017 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг товч танилцууллаа. Та бүхэнд тарааж өгсөн 2017 оны жилийн тайлангаас бусад дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. Мөн асуулт хариултын хэсэгт илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Баярлалаа.

3.2 ХЭЛЭЛЦСЭН нь:

ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудал, дэгийн дагуу ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулсан тайланд хийсэн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

Говь ХК-ийн ТУЗ нь тус компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн батлаад компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэхдээ компанийн тухай хууль, холбогдох хууль дүрэм журам, хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан Говь ХК-ийн дүрмийг чандлан мөрдөж ажиллаж ирлээ. Гүйцэтгэх удирдлагын багийн хувьд ТУЗ-ийн зүгээс гаргасан шийдвэр зөвлөмж, төлөвлөгөө зорилтуудыг амжилттай дагаж биелүүлэх чиглэлээр хамтарч ажилласан болно. 2017 оны ерөнхий гүйцэтгэлийг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Н.Сүрэнрагчаа та бүхэнд танилцууллаа.

Бид бүгдийн хувьд үйлдвэрлэлийн өндөр бүтээмж, үр ашигтай байдлыг чухал хэмээн үзээд хүрээлэн байгаа орчиндоо тогтвортой, ээлтэй удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах замаар бизнесийн өсөлтийн стратегийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд компанийн зах зээлийн үнэлгээ 181.4 тэрбум төгрөгт хүрч 2016 онтой харьцуулахад 129%-иар өслөө. Тайлант хугацаанд ажилтнуудын бүтээмж дунджаар 28% өсөж, дундаж цалин 10%-иар өсөх боломж бүрдсэн.

Мөн гадаад, дотоод захиалгыг үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаатай нягт уялдуулах, түүхий эдийн татан авалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, үйлдвэрлэлийн бүтээмж, чанарыг дээшлүүлэх тал дээр цогц арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2017 оны борлуулалтын орлого 113%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Түүхий эд бэлтгэлийг бид 2016 оноос 54%-иар өсгөж чадлаа. Тайлант хугацаанд компанид нийт 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 3.3 тэрбум төгрөгийг үйлдвэрийн өргөтгөл хийх, 7.4 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж нэмэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зарцуулсан.

Иймд ТУЗ-ийн зүгээс Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 оны төлөвлөгөө зорилтуудаа биелүүлэхийн тулд бүх нөөц бололцоогоо дайчилж ажиллаа гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа. Хэлэлцүүлгийн хэсэгт асууж тодруулах зүйлээ асууна уу.

3.3 ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн тухай дүрмийн төслийг танилцуулах

Хуулийн зөвлөх Ц.Цасчихэр танилцуулав.

Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн засаглалыг сайжруулахын тулд сүүлийн жилүүдэд дүрэмдээ тодорхой өөрчлөлтүүдийг оруулан ажиллаж байгаа. Энэ удаад мөн адил компанийн засаглалыг сайжруулах, компани өргөжин тэлж байгаатай холбоотой дараах өөрчлөлтүүдийн саналыг тусгасан. Эдгээр өөрчлөлтүүд нь шинэ зүйлс биш, харин байгууллагын үнэ цэнэ, гүйцэтгэх удирдлагын үнэ цэнийг илүү тодотгож өгсөн саналууд байна. Үүнд:

6.2.2 ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна. **гэсэн заалтыг**

6.2.2 ТУЗ нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна. **хэмээн өөрчлөлт оруулсан.**

6.2.7.11 ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах; **гэсэн заалтыг**

6.2.7.11 ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах **хэмээн өөрчлөлт оруулсан.**

6.3.3.4 Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх; **гэсэн заалтыг**

6.3.3.4 Компанийн дотоод журам, үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх; **хэмээн өөрчлөлт оруулсан.**

6.3.3.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах; **гэсэн заалтыг**

6.3.3.6 ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй шууд харилцаж, тэдэнтэй гэрээ, хэлэлцээр байгуулах; **хэмээн өөрчлөлт оруулсан.**

6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах; **гэсэн заалтыг**

6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн бүтэц, орон тоог бие даан баталж мөрдүүлэх; **хэмээн өөрчлөлт оруулсан.**

6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх; **гэсэн заалтыг**

6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоод болон гадаад орнуудад мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх; **хэмээн өөрчлөлт оруулсан.**

Та бүхэн эдгээр саналуудыг дэмжинэ үү.

3.4 ХЭЛЭЛЦСЭН нь:

2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Та бүхэнд тарааж өгсөн жилийн тайлангийн 62-р хуудаст Говь ХК-ийн хувьцааны арилжаа болон хувьцаатай холбоотой мэдээллүүд дэлгэрэнгүй байгаа. Ногдол ашигтай

холбоотой мэдээллийг танилцуулахаас өмнө хувьцааны арилжааны мэдээллийг товчхон хүргэе.

2017 онд Говь ХК-ийн хувьцааны дундаж үнэ 16,535 төгрөг байсан ба 2016 онтой харьцуулахад 96%-ийн өсөлттэй байна. Хувьцааны хамгийн өндөр үнэ 35,180 төгрөгт хүрсэн ба өмнөх 2016 онтой харьцуулахад 202%-иар өссөн байна. 2017 оны хувьцааны хаалтын ханш 23,260 төгрөг ба энэ нь 2016 оноос 129%-ийн өсөлттэй байна.

Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд нийт 140,047 ширхэг хувьцаа арилжаалагдсан ба өдөрт дунджаар 579 ширхэг хувьцаа арилжаалагдсан байсан байна. Нэг өдөрт хамгийн их арилжаалагдсан тоо нь 15,286 ширхэг байна. Энэ нь 2016 онтой харьцуулахад 216%-иар өссөн байна.

Арилжааны үнийн дүнгээр авч үзвэл нийтдээ 2.6 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан ба дунджаар өдөрт 10.8 сая төгрөгийн хувьцаа арилжаалагдсан байна.

Компанийн зах зээлийн үнэлгээ 181.4 тэрбум төгрөг болж 2016 оноос 129%-иар өссөн байна. Хувьцаа эзэмшигч та бүхний хувьд эзэмшиж байгаа хувьцааны үнэлгээ зах зээлд өсөлттэй байсан сайхан жил болсон гэдгийг дуулгахад таатай байна.

Ингээд 2016 оны ногдол ашгийн тараалтын тайланг танилцуулъя. 2016 онд нэгж хувьцаанд 200 төгрөгийн ногдол ашиг зарласан. Нийт дүнгээр 1.6 тэрбум төгрөгийг ногдол ашиг тараасан. 2017 ондоо багтаад ногдол ашгаа 100% тараасан ба компани дээр нийт ногдол ашгийн 89.5%-ийг буюу ойролцоогоор 1.4 тэрбум төгрөгийг тараасан. 2017 оны эцэст буюу 12-р сарын 26-ны өдөр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан үлдэгдэл тооцоогоо гарган 163 сая төгрөгийн ногдол ашгийг шилжүүлэн байршуулсан байгаа. Ногдол ашгаа авч амжаагүй хувьцаа эзэмшигч байвал өөрийн харьяалагддаг үнэт цаасны компаниас ногдол ашгаа авах боломжтой.

Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд 2010 оноос хойш тасралтгүй ногдол ашиг олгосоор ирсэн. ТУЗ-өөс баримталж байгаа ногдол ашгийн бодлогын хувьд хэрэв компанийн цэвэр ашиг өмнөх жилээсээ буураагүй байгаа тохиолдолд ногдол ашгийн хэмжээг тасралтгүй нэмэгдүүлнэ гэсэн бодлогыг баримталдаг.

2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 220 төгрөгийн ногдол ашиг зарласан ба энэ нь 2016 оноос 10%-иар өссөн үзүүлэлттэй байна. Нийтдээ 1.7 тэрбум төгрөгийг ногдол ашигтаа олгоно хэмээн шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хувьд 2018 оны 03-р сарын 27-ны өдрөөр Говь ХК-ийн хувьцааг эзэмшиж байсан бүх хүн авах эрхтэй.

Тараах арга хэлбэрийн хувьд 2018 оны 04-р сарын 24-ний өдрөөс эхлэн Говь ХК дээр олгож эхэлнэ. Та бүхэн өөрийн биеэр болон мөн зардал чирэгдэл ихтэй байж болзошгүй тул заавал биеэр ирэхгүйгээр холбогдох и-мэйл хаягаар мэдээллээ явуулан /иргэний үнэмлэхийн хуулбар/ банкны харилцах дансанд мөнгөө шилжүүлж авах боломжтой. 2018 оны эцэст бүх тооцоогоо гарган үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаар дамжуулан шилжүүлэх болно.

3.5 ХЭЛЭЛЦСЭН нь:

ТУЗ-ийн гишүүдийг батлах

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Говь ХК нийт 9 ТУЗ-ийн гишүүдтэй. Үүнээс хараат бус гишүүдээр 5 хүнийг, ердийн гишүүдээр 4 хүний тус тус дэвшүүлж байна. Одоо танилцуулах 9 гишүүний 8 нь 2016 оны

хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан гишүүд байгаа. Дахин сонгууль явуулж байгаа шалтгаан нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 2017 оны дундуур өөрчлөлт орсон. Т.Одмаа гишүүн өөрийн саналаар ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөн. Иймээс ТУЗ-өөс Зуунайн Шагдарсүрэн гишүүнийг түр томилсон байгаа. Тиймээс өнөөдрийн хурлаар бүх гишүүдийг дахин батлахаар болсон.

Говь ХК-ийн хувьд ТУЗ-ийн гишүүд нь салбартаа тэргүүлэгч, салбар салбарын төлөөлөл болсон гишүүд байдаг. Жишээлбэл: Оёдлын үйлдвэрийн технологич инженер, Санхүүч, Эдийн засагч, Хууль эрх зүйч, Маркетинг борлуулалт гэсэн бүхий л салбарын арвин туршлагатай чадварлаг хүмүүсээр ТУЗ-ийн гишүүдээ бүрдүүлсэн байгааг бахархалтайгаар хэлэх нь зөв байх.

ТУЗ-ийн гишүүд гэдэг бол хувьцаа эзэмшигч та бүхний төлөөлөл гэсэн үг. Тиймдээ ч өдөр тутамдаа компанийн гүйцэтгэх удирдлагын багийг чиглүүлэн, стратегийн бодлогоор ханган, үйл ажиллагааг нь үнэлж дүгнэн хянаж явдаг байгаа.

Гишүүдийн товч танилцуулгыг хийхээс өмнө нэр дэвшигчдийн хувьцаа эзэмшдэг байдлыг танилцуулъя. Д.Хулан нэр дэвшигч дангаараа 122,473 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 1.6%, Ц.Баатарсайхан нэр дэвшигчийн хувьд дангаараа 500 ширхэг хувьцаа эзэмшдэг нь ойролцоогоор 0.01%-ийг эзэмшдэг гэсэн үг. Уг 2 хувьцаа эзэмшигчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хүргэхэд, Ц.Баатарсайхан хувьцаа эзэмшигч нь Таван Богд Группийн ерөнхийлөгч, Д.Хулан нэр дэвшигч нь Таван Богд Группийн тэргүүн дэд ерөнхийлөгч гэсэн албан тушаалыг хашдаг. Үүнээс үзэхэд Таван Богд Группийн толгой компани болох Таван Богд Трейд компани нь Говь ХК-ийн 21.5%-ийг эзэмшдэг, охин компани болох ЭФ-СИ-АЙ ХХК Говь ХК-ийн 28.6% эзэмшдэг. Ингээд нийт дүнгээр аваад үзэхэд эдгээр 2 нэр дэвшигч маань 51.7%-ийг эзэмшдэг.

Гишүүдийн товч танилцуулга:

Үүнд: *Хараат бус гишүүд*

1. Мягмарын Баяр
Оёдлын үйлдвэрийн технологич мэргэжилтэй. 2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. Одоо ШУТИС-ийн Нэхмэл судлалын салбарын дэд профессор, Хувцас судлалын төвийн захирлын албан тушаалыг хашдаг.
2. Дамбын Гэрэлмаа
Эдийн засагч мэргэжилтэй. 2013 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессороор ажилладаг.
3. Банзрагчийн Нандин-Эрдэнэ
Бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн. 2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхимийн ахлах багш, "Аксиом Инк" ХХК-д захирлын албан тушаалыг хашдаг.
4. Такэши Камбэ
Эдийн засагч мэргэжилтэй. 2008 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. Япон улсын иргэн.
5. Зуунайн Шагдарсүрэн
Хуульч, Эрх зүйч мэргэжилтэй. Япон улс, Токиогийн их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалавр болон магистр зэрэгтэйгээр төгссөн. Мөн Америкийн нэгдсэн улсын

Мичиганы их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн. 2017 оны 12-р сараас Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр түр томилогдон ажиллаж байгаа.

Ердийн гишүүд:

6. Цагаачийн Баатарсайхан
Электроникийн инженер мэргэжилтэй. 2007 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. 2008 оны 08-р сараас эхлэн Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон.
7. Жавзандолгорын Оюунчимэг
Сэтгүүлч мэргэжилтэй. 2016 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. Таван Богд Групп-д маркетингийн хэлтсийн даргаар ажилладаг.
8. Хидэо Савада
Эдийн засагч мэргэжилтэй. 2009 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.
9. Дашдаваагийн Хулан
Эдийн засагч мэргэжилтэй. 2008 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа. Таван Богд Фүүдс ХХК, Таван Богд Фүүдс Пицца ХХК-н гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Мөн Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажилладаг.

За ингээд 9 гишүүний танилцуулгыг товч хийлээ. Та бүхэн дэлгэрэнгүй мэдээллийг жилийн тайлангийн номоос харан сонголтоо хийнэ үү. Баярлалаа.

3.6 ХЭЛЭЛЦСЭН нь:

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай танилцуулах
ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүд нь бүгд нарийн мэргэшсэн, туршлагатай, салбартаа тэргүүлдэг хүмүүс байгаа. Эдгээр гишүүдийн мэргэжлийн мэдлэг, чадвар нь Говь ХК-ийн хөгжил, компанийн зах зээлийн үнэлгээ өсч байгаад маш их нөлөөтэй. Мөн гаргаж байгаа шийдвэрүүд нь оновчтой, даацтай байгаа нь компанийн одоогийн үйл ажиллагаанаас харж болох болов уу.

2013 оноос хойш ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийн цалин урамшуулалд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байгаа. Олон улсын хэмжээнд боловсрол эзэмшсэн мастер, докторын зэрэгтэй мэргэжилтнүүд зах зээл дээр ямар үнэлгээтэй байдгийг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэх байх. Цалин, урамшууллын хорооны даргын хувьд эдгээр 8 гишүүний мэдлэг, ур чадвар, цагийг бодитой үнэлж, цалин урамшууллыг нэмэгдүүлэх санал оруулж байна.

Нөгөө талаар бид өнгөрсөн 2016, 2017 оныг харахад зах зээлийн үнэлгээ нэлээдгүй өслөө, хөдөлмөрийн бүтээмжийг сүүлийн 2 жилийн турш тасралтгүй нэмэгдүүлж дунджаар 20-28%-иар өсгөлөө. Ажилтнуудын цалинг ч мөн байнгын өсөлттэй түвшинд авч явж байна.

Энэ бүгдийн төгсгөлд та бүхний сонголт, шийдвэрийг дахин баталгаажуулах зорилгоор мэдээлэл өгөхөд Говь ХК-ийн засаглалын өөрийн үнэлгээг хийж үзсэн байгаа. Энэ мэдээллийг компанийн болон хөрөнгийн биржийн сайтад байршуулсан байгаа. Мөн жилийн тайлангийн

51-р хуудаст тусгасан болно. Засаглалын өөрийн үнэлгээ хийж үзэхэд 81.5%-ийн гүйцэтгэлтэй гарч байгаа нь ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүд маань үүрэгт ажлаа маш сайн хийж байгаа, ажлын үр дүн сайн байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Та бүхнийг энэ мэдээллийг анхааралдаа авна уу гэсэн хүсэлтэй байна.

Цаашид ТУЗ-ийн ажиллах чиглэлийг улам тодорхой болгож засаглалаа илүү сайжруулах ажлуудыг төлөвлөсөн байгаа. Энэ бүх ажлуудыг манай ТУЗ-ийн гишүүд хийнэ. Тиймээс цаашид гишүүдийн цалин урамшуулал, цагийн үнэлгээг илүү бодитой болгож өгнө үү гэдэг хүсэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж байна.

Тогтмол цалинг үндсэн гишүүн 500,000 төгрөг байгааг 1,000,000 төгрөг, ТУЗ-ийн даргын нэмэгдлийг 400,000 төгрөг байгааг 800,000 төгрөг, Хорооны даргын нэмэгдлийг 150,000 төгрөг байгааг 300,000 төгрөг болгон нэмэгдүүлэх саналыг оруулж байна.

4. СОНССОН нь:

Асуулт хариулт /хүн тус бүр 3 минут/

Асуулт 1

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: 2017 онд Гоёо ХХК-ийг Таван Богд Групп болон Говь ХК-тай холбоотой хуулийн этгээд худалдаж авсан гэсэн мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр энэ 2 компани цаашдаа бизнесийн үйл ажиллагаа явуулахдаа хоорондоо ямар уялдаа холбоотой, ямар зарчмаар ажиллах вэ? Магадгүй гадаад зах зээлд Говь ХК нь илүү ажиллах, эсвэл Гоёо ХХК нь илүү ажиллах эсвэл харилцан бие биеэ дэмжиж ажиллах уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Гоёо ХХК-ийг 2017 оны 12-р сард Таван Богд Трейд компани худалдаж авсан. 2016 онд Говь ХК дангаараа Гоёо ХХК-ийг худалдаж авах талаар хэлцэл хийж байсан боловч Говь ХК өөрийн санхүүгийн эх үүсвэрээр авах боломжгүй болсон. Таван Богд Трейд ХХК Гоёо ХХК-ийг худалдаж авснаас хойш энэ 2 компани хоорондоо өрсөлдөх зүйл дээрээ өрсөлдөж, бие биеэ дэмжиж ажиллах зүйл дээрээ дэмжиж ажиллахаар болсон. Та бүхэн мэдэж байгаа байх, 2016 оноос эхлэн Монгол улс дэлхийн нийт ноолуурын хэрэглээний 50%-ийг дангаараа гаргаж байгаа хэрнээ дөнгөж 10%-ийг эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгож байгаа нь хангалтгүй үзүүлэлттэй байгаа. Монголын ноолууран бүтээгдэхүүний салбарт Говь ХК, Гоёо ХХК, Эвсэг ХХК компаниуд хамгийн том байр суурийг эзэлдэг.

Асуулт 2

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Менежментийн багийн гишүүд болон нийт удирдлагууддаа баяр хүргэе. 2017 онд Говь ХК нь 100 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Зээлийн зарцуулалт юунд ашиглагдаж байгаа бэ? Бараа материалын татан авалт 43%-иар өссөн байна. Мөн компанийн үйл ажиллагааны зардал нилээд өссөн үзүүлэлттэй байна. Цаашид ч мөн өсөхөөр харагдаж байна. Ямар шалтгаанаар өсөж байгааг тайлбарлана уу?

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК 2017 онд 743 тонн түүхий эд худалдаж авсан. 2018 онд 850 тонн түүхий эд худалдаж авахаар зорьж ажиллаж байгаа. Сүүлийн 3 жил буюу 2016-2018 онд Говь ХК багагүй өөрчлөлтүүдийг хийж ажиллаж байна. Яагаад гэвэл 4 жилийн өмнө Говь ХК хавраас намар хүртэл их ажилтай бусад үед нь үйлдвэрийн ажилтнууд ажил

багатай байдаг байсан. Өнөөдрийн байдлаар Ээрмэлийн үйлдвэрийн хувьд авч үзвэл түүхий ноолуураас бэлэн утас үйлдвэрлэдэг бөгөөд 4 ээлжээр ажиллаж Говь ХК-ийн түүхэнд өмнө байгаагүй 360 тонн утас үйлдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл өдөрт 1 тонн утас үйлдвэрлэсэн. Энэ 360 тонн ноолууран утас нь 2017 онд Монгол улсад үйлдвэрлэсэн ноолууран утасны 80%-ийг эзэлж байгаа. Утасны нөөц үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралгүй ажиллуулах хангалттай хэмжээгээр нөөцлөгдөж байгаа. Та бүхэн хүсвэл утасны болон бэлэн бүтээгдэхүүний агуулахыг үзэж болно.

Зээлийн хувьд банкнаас их хэмжээний зээл авах асуудал их бэрхшээлтэй болсон. Засгийн газраас Ноолуур хөтөлбөр хэрэгжүүлэн асар хөнгөлөлттэй зээл олгож байгаа хэмээн сонин хэвлэлээр ярьж байгаа боловч өнөөдрийн байдлаар нэг ч төгрөгийн зээл авч чадсан компани байхгүй байгаа. Говь ХК-ийн хувьд зах зээлд бий болгосон итгэлцэл, ажилтнуудын хүч чадал дээр тулгуурлаж арилжааны банкнууд, Европын сэргээн босголт хөгжлийн банкнуудаас зээл авсан ба Азийн хөгжлийн банкнаас дэлхийн бусад орнуудтай адил зээлийн хүү, адил нөхцөлтэйгөөр зээл авсан. Зээлийн эхний ээлжийн санхүүжилт болох 10 сая доллар 2018 оны 06-р сард орж ирнэ.

Та бүхэн мэдэж байгаа байх, Говь ХК өмнө нь Монгол улсад үйлдвэрлэж байгаа 1,000 тонн ноолуурыг самнаад гаргадаг үйлдвэр байсан. Гэвч хувьчлагдсанаас хойш нэг тонн ч ноолуурыг самнаж гаргаагүй. Цаашдаа ажиллах зарчим ч мөн ийм байгаа. Ямаанаас пальто хүртэл бүх үйлдвэрлэлийг өөрсдөө хийнэ. Говь ХК өмнө нь зөвхөн сүлжмэл бүтээгдэхүүн хийдэг үйлдвэр байсан бол сүүлийн жилүүдэд нэхмэл ороолт, шааль үйлдвэрлэдэг болсон. Мөн 2008 онд анх ноолууран пальто үйлдвэрлэж эхлээд 100 пальто хийгээд 30 пальто борлуулдаг байсан бол 2017 онд 30 мянган пальто зарж чадсан.

Сүүлийн үед Говь ХК-ийн ажилтнуудаас БНСУ-ын визэнд орж уг улсыг зорьж 3 сараар ажиллах хүний тоо нэмэгдэж байгаа. Бид чадвартай ажилтан бэлтгэхийн тулд 3-5 жил зарцуулдаг. Бид өөрсдийн бэлдсэн ажилтнуудаа гаднын улс оронд алдахгүйн тулд тэдэнд өрсөлдөхүйц хэмжээний цалин өгөх хэрэгтэй. Тиймээс компанийнхаа бүтээмжийг нэмэгдүүлж ажилтнуудынхаа цалинг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллаж байгаа.

Асуулт 3

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: ТУЗ-ийн гишүүдийн цалинг 2013 онд тогтоосон хэмжээнээс ажилтнуудын цалин хэрхэн өссөн байдалтай уялдуулан тогтоох нь зөв болов уу.

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК-ийн ТУЗ-д салбартаа тэргүүлэгч болсон өндөр чадвартай хүмүүс ажилладаг. Бид энэ мундаг боловсон хүчнүүдийг урьж ажиллуулдаг. Тиймээс бид энэ хэмжээний цалинг олгохгүй бол энэ хүмүүс бидэнд ажиллаж өгөхгүй байх талтай. Бид ТУЗ-д орохыг хүссэн хүн бүхнийг ажиллуулдаг биш илүү чадвартай, илүү зөв санаа, илүү зөв зөвлөмж өгч чадах хүмүүсийг урьж ажиллуулж байгаа.

Асуулт 4

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: 2017 онд Говь ХК-д 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн гэдэг мэдээлэл авлаа. Энэ хөрөнгө оруулалтын эргэн үр дүнгээ өгөх хугацаа ямар байгаа бэ? Говь ХК нь 1,900 гаруй ажилтантай. ТУЗ-ийн гишүүдийн тоо 11 хүртэл байх гэдэг санал зөв санагдаж байна.

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 3-5 жилдээ нөхөгддөг.

Асуулт 5

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Ц.Баатарсайхан захирал, Д.Хулан захирал нарт хандаж хэлэх санал байна. Ц.Баатарсайхан захирлын хувьд Таван Богд Группийн ерөнхийлөгчийн ажил үүргээ гэр бүлийнхээ хэн нэгэнд өгөөд өөрөө зөвхөн Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлын ажил үүргээ хийх боломж байдаг уу? Таны хувьд нэлээд ачаалалтай ажилладаг байгаа.

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Компанийн тухай хуулийн дагуу би ямар нэгэн байдлаар хууль зөрчиж компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдоогүй. Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлаар Япон улсад боловсрол эзэмшсэн Н.Сүрэнрагчаа захирлыг томилон ажиллуулж байна. Миний хувьд харьцангуй залуу хүнийг Говь ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирлаар томилсны хувьд юу нь болж юу нь болохгүй байгааг зааж зөвлөж ажиллах шаардлагатай байгаа. Чадварлаг боловсон хүчин, чадварлаг удирдлага бэлтгэгдэж бэлэн болсон үед би өөрийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг шилжүүлэн өгөхөд хэзээд бэлэн байгаа.

Асуулт 6:

Хувьцаа эзэмшигч Ангарагбат: Говь ХК болон Гоёо ХХК 2-ыг цаашид нэгтгэх бодол байгаа юу? Мөн би саяхан Говь ХК гэсэн логотой prius 50 авто машиныг замын хөдөлгөөнд оролцож байхыг харсан. Уг машины зах зээлийн үнэлгээ 67 сая төгрөг байсан. Яагаад ийм үнэтэй машин авсан бэ? Өөр компанийн зарагдахгүй байгаа барааг Говь ХК заавал авах шаардлагатай юу? ТУЗ-ийн хурал болсноор ТУЗ-ийн гишүүд жилд 100 сая гаруй төгрөгийг зөвхөн хуралд оролцсон гэсэн шалтгаанаар авч байна. Ингэж авах ёстой юу? ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг 2017 оны борлуулалт хэдэн хувиар өссөн дүнтэй харьцуулж олгох саналыг дэвшүүлж байна.

Хариулт:

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК, Гоёо ХХК 2 нэгдэх боломжгүй гэж харж байгаа. Жишээ нь БНСУ-ын зах зээлийг аваад үзэхэд тэдний зах зээлд Говь ХК-ийн бүтээгдэхүүнийг зөвхөн нэг компани дистрибьютор хийдэг. Гадаадын улс орнуудад нэг улсад нэг л компани дистрибьютор хийх боломжтой байдаг. Гэтэл Говь ХК, Гоёо ХХК 2 нэгдсэн тохиолдолд гадаад улс оронд зөвхөн нэг компани нь дистрибьютор хийх боломжтой болно. Тийм болохоор 2 компани нэгдэх нь ашиггүй сонголт юм. Харин Гоёо ХХК-г Таван Богд Трейд ХХК худалдаж авснаар өмнө нь 2 компани цэвэр өрсөлдөх зарчмаар ажилладаг байсан бол одоо 2 компанийн хооронд хамгийн наад зах нь боловсон хүчнээ булаалдахгүй гэсэн тохиролцоонд хүрсэн. Нэг боловсон хүчнийг дагаж компанийн бизнесийн явж байдаг тул бидний хийсэн тохиролцоо хамгийн зөв болов уу хэмээн бодож байна.

Prius 50 авто машины хувьд манай газрын захирлуудын түвшинд шинэ хуучин Prius авто машинуудыг унадаг. Таван Богд Toyota компани Монгол улсад борлуулагдаж байгаа нийт Toyota маркийн авто машинуудын 80%-ийг борлуулдаг. Тиймдээ ч зах зээлийн хамгийн боломжийн үнийг санал болгож санхүүгийн шийдлээрээ худалдаалсан байгаа. Говь ХК Таван

Богд Toyota компанийн борлогдохгүй бүтээгдэхүүнийг авсан тохиолдол байхгүй. Бид тийм зарчмаар бизнесээ явуулдаггүй.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: ТУЗ-ийн гишүүдийн эрхээ хэрэгжүүлдэг, ажил үүргээ биелүүлдэг талбар нь ХУРАЛ. Жилд ТУЗ-ийн хурал 6 удаа болдог, хороодын хурал янз бүрийн тоотой, Нэр дэвшүүлэх хорооны хурал жилд 2 удаа, Цалин урамшууллын хорооны хурал жилд 2 удаа, Эрсдэл аудитын хороо жилд 4 удаа хуралддаг. Энэ хурлуудаар дамжуулж хувьцаа эзэмшигч та бүхний эрхийг хэрэгжүүлэх, хяналтаа тавих үйл ажиллагаанууд явагддаг. Хурал өөрөө маш үнэтэй цаг. Тиймээс үнэлж өгөх шаардлагатай хэмээн үзэж байна.

5. СОНССОН нь:

Санал шүүмжлэл /хүн тус бүр 3 минут/

Санал, шүүмжлэл 1:

Санхүү бизнесийн дээд сургуулийн оюутан Бат-Эрдэнэ: Говь ХК 2017 онд 17.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Цэвэр ашгийг 10%-ийн ажилтнууддаа тарааж өгч болох уу? гэдэг санал дэвшүүлж байна.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Компани цэвэр ашгаасаа хэдэн хувийн ажилтнууддаа өгөх нь компанийн өөрийн бодлого. Бид ажилтнуудад жил бүр үр дүнгийн урамшуулал өгч ажилладаг. Харин компанийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг авах нь илүү үр өгөөжтэй гэж бид үздэг. Бид 2017 оны цэвэр ашгийн 10%-ийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчиддээ тарааж байгаа.

Санал, шүүмжлэл 2:

Санхүү бизнесийн дээд сургуулийн оюутан: Говь ХК нь уриа үгээ солих цаг болсон. Жишээлбэл Ордос компанийн уриа үг нь “Ордос дэлхийг дулаацуулахын тулд” гэсэн байдаг. Харин Говь ХК-ийн уриа үг нь “Дэлхийд танигдсан Монгол брэнд” гэдэг. Тиймээс уриа үгэндээ Монгол ноос ноолуурын давуу талыг тусгах хэрэгтэй. Мөн компанийн лого дээр ямааны дүрс нэмж оруулах санал дэвшүүлж байна.

Санал, шүүмжлэл 3:

Хувьцаа эзэмшигч Хүрэлбаатар: Говь ХК-ийн хамт олонд 2017 онд амжилттай ажилласанд нь нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнөөс талархал илэрхийлье. Зарчмын санал байна. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал сүүлийн жилүүдэд нэмэгдээгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа тул цалин урамшууллыг нэмэх саналыг дэмжиж байна. Мөн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах асуудалд нэлээн анхааралтай ажиллахыг хүсэж байна. Хувьцаат компанийн хувьд 3 зүйл маш чухал 1. Хувьцаа эзэмшигчид, 2. Ажилтнууд, 3. Хамтран ажиллагсад. Тиймээс чухал зүйлсийн нэг болсон ажилтнуудын цалин урамшуулалд Үйлдвэрчний эвлэлийн хороотойгоо хамтран сайтар ажиллах хэрэгтэй. Мөн ажилтнуудын нийгмийн халамж талаасаа Говь ХК-ийн үйлдвэрийн барилгын урд байрлах хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг ашиглалтад оруулах, түүгээр дамжуулж ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах боломжийн нэмэгдүүлэх гэдэг саналуудыг та бүхэнд тавьж байна. 2018 ондоо нилээдгүй олон хөрөнгө оруулалтыг хийсэн болохоор 2019 ондоо илүү дайчин төлөвлөгөөнүүдийг гаргаж ажиллахыг хүсэж байна. За ингээд нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнөөс дахин талархал илэрхийлье. Бүгдээрээ Говиороо гангарцгаая.

Санал, шүүмжлэл 4:

Хувьцаа эзэмшигч Амарсайхан: Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан, ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа нараас уучлал хүсэн дараах асуудлуудыг дэвшүүлж байна. Хуралд муу бэлдсэн байна. Энд байгаа микрофонууд бүгд ажиллахгүй байна. Жилд нэг удаа болж байгаа хурлыг ингэж оромдож болохгүй ээ. Техник технологийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж ажиллах хэрэгтэй. Компанийн удирдлагууд хуралд муу бэлдсэн байна. Бидэнд тайлан биш тайлбар тавьж байна. Миний хувьд арай өөр зүйл хүсэж байсан. Компанийн үйл ажиллагааны юу нь болж байна юу нь болохгүй байна гэдгийг ярих болов уу гэдэг хүлээлттэй байлаа.

Компани хувьчлагдсанаасаа хойш ногдол ашиг тараахдаа харамч ээж шиг маш бага хэмжээгээр ногдол ашиг тарааж байна. Бараг 10 гаруй жил хувьцаа тарлаа. Энэ бүх тараасан хувьцаа нийлээд хэдэн төгрөг болсныг та бүхэн бодож үзсэн үү? Та бүхний бодож байгаа жижиг хувьцаа эзэмшигчид бол нийлээд том хувьцаа эзэмшигчид юм шүү.

Цаашид хурлаа илүү сайн хийхийг хүсэж байна. Болж бүтэхгүй байгаа зүйлээ сайн ярих хэрэгтэй байна.

Тайлбар Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтаараа Монголын зах зээлийн 70 хувийн эзэлдэг. Бид жилийн 365 хоног тасралтгүй ажилладаг. Жишээлбэл манай үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүр жилд 3 өдөр л амардаг. Монголд ингэж үйл ажиллагаа явуулдаг компаниуд хэр их байдаг билээ. Засгийн газрын хөнгөлөлттэй зээл олгоно гэдэг мэдээлэл маш их гарч байгаа ч өнөөдрийг хүртэл нэг ч төгрөгийн зээл гараагүй байгаа. Тэглээ гээд бид тайлбар тавьдаггүй. Энэ бол бидний хийх ёстой ажил. Та бүхэн мэдэж байгаа байх, Говь ХК ноолууран пальто, сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэг харин бид 2018 онд ноолууран пиджакны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч компани болохыг зорьж ажиллаж байгаа. Үүний тулд 2018 оны сүүл гэхэд ажилтнуудынхаа тоог 2,000-д хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. Бид 2017 онд ажилтнуудынхаа тоогоор Монголд улсдаа дээрээсээ 5-д бичигдсэн бол 2018 онд 4-т бичигдэхээр харагдаж байна.

Санал, шүүмжлэл 5:

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Миний бие хувь хүнийхээ хувьд 10 жилийн турш хувьцааны бизнест ажиллаж байгаа. Олон компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байсан. Сүүлийн үед компаниудын хурал харьцангуй сайжирч байгаа. Жишээлбэл би 3 жилийн өмнө 2015 онд Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байсан. Жижигхэн өрөөнд 2, 3 захирал нь суусан, загнаад ч байгаа юм уу, яагаад байгаа нь мэдэгдэхгүй хурал болж байсантай харьцуулахад илүү сайжирсан байна. Бид олон улсын түвшинд богино хугацаанд хүрэх боломжгүй, олон жилийн туршлага хэрэгтэй. Ингээд та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

Тайлбар Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Монгол улсдаа үйлдвэрлэлээ явуулаад түүхий эдээс эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэл бүх дамжлагуудаа 100% өөрсдөө хийж дотоодын болон гадаадын зах зээлд борлуулж байгаа компани Монгол улсад хэд байдаг бэ? Би тийм ч олон байдаггүй гэж бодож байна. Бидний өрсөлдөгч болох Ордос компанийн хувьд 3 хувийн хүүтэй юанийн зээлтэй, 5 мянган ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Гэтэл бид 12-18%-ийн хүүтэй зээлээр санхүүжилт аван ажиллаж байна. Ордос компанийн эзэд 2017 онд манай компани дээр хүрэлцэн ирсэн. Би мөн өөрөө Ордосын үйлдвэрийн очиж үзэж байсан.

160 га талбайд 5 мянган хүн ажиллаж, улсын бодлогоор компанийнхаа үйл ажиллагааг дэмжиж байдаг. Гэтэл бидэнд Хөдөө аж ахуйн биржээс эхлээд ноолуурын үнэ л өсгөж байвал боллоо гэдэг байдлаар ханддаг. Нэг талдаа түүхий эдийн үнэ өсөөд малчдын гар дээр очих орлого нэмэгдэж байгаа боловч нөгөө талдаа энэ өндөр үнийг даваад хэдэн ноос ноолуурын үйлдвэр хэвийн ажиллаж чадах вэ гэдгийг бодож үзээрэй. Говь ХК энэ бүхнийг даваад гарна. Говь ХК-ийн хамгийн үнэтэй зүйл бол 1,820 ажилтан юм шүү. Тиймээс энэ ажилтнуудын цалин хөлс, нийгэм ахуйн нөхцөлийг нэмэгдүүлж ажиллах нь хамгийн чухал байна.

Ногдол ашиг бага тарааж байна гэдэг санал ирсэн. Энэ асуудалтай нэг талаар санал нийлж байгаа ч нөгөө талдаа компанийн хувьцаа тасралтгүй өсөж байгаа нь хамгийн чухал гэж бодож байна.

Санал, шүүмжлэл 6:

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Говь ХК-ийн ажилтнууд, удирдлагуудад баяр хүргэж байна. Та бүхэн сайн ажиллаж байна. Хүний сэтгэл нь сайн байвал үйлс нь сайн байдаг гэдэг. Хүний урмыг хугалахаар ууцыг хугал гэсэн үг байдаг. Урам гэдэг бол хамгийн чухал зүйл. Тиймээс та бүхэндээ дахин дахин ажлын амжилт хүсье. Маш сайн ажиллаж байна. Та бүхний сэтгэл, үйлс нь үргэлж сайн сайхан байх болтугай. Хамгийн хайртай байх ёстой зүйл бол ажилтнууд шүү. Эрүүл бие саруул тунгалаг ухаанаар хэдэн ямааныхаа буянаар Монгол улсаа тэнгэрт гартал нь өргөөрэй.

6. САНАЛ ХУРААЛТЫН ДҮН

Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэснээ танилцуулав. Тооллогын комиссын дарга Ч.Солонго:

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын дүнг танилцуулъя.

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт 6,946,873 саналын эрхтэй, 210 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 89.05 % байв.

Хоёр. Санал хураах хайрцгаар 175 ширхэг саналын хуудас хураагдсанаас:

1. Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах асуудал дээр
 - A. Хүчинтэй саналын хуудас 160 ширхэг
 - B. Хүчингүй болсон саналын хуудас 15 ширхэг байв.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай батлах асуудал дээр
 - C. Хүчинтэй саналын хуудас 160 ширхэг
 - D. Хүчингүй болсон саналын хуудас 15 ширхэг байв.
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал дээр
 - A. Хүчинтэй саналын хуудас 125 ширхэг
 - B. Хүчингүй болсон саналын хуудас 50 ширхэг байв.
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай батлах асуудал дээр
 - E. Хүчинтэй саналын хуудас 160 ширхэг
 - F. Хүчингүй болсон саналын хуудас 15 ширхэг байв.

Гурав. Брокерийн пүүсүүдээр дамжуулж ирүүлсэн саналын хуудас 6 ширхэг байв.

Дөрөв. Хурлаар хэлэлцсэн асуудалд санал өгсөн байдал:

1. ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

- Зөвшөөрсөн 99.88%, татгалзсан 0.00 %, түдгэлзсэн 0.12%;
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахыг батлах тухай
Зөвшөөрсөн 99.85%, татгалзсан 0.00 %, түдгэлзсэн 0.14%;
3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай
- | | |
|-------------------------------------|--|
| <i>а. ТУЗ-ийн хараат бус гишүүд</i> | <i>Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо</i> |
| 1. М.Баяр | 7,032,155; |
| 2. Д.Гэрэлмаа | 6,913,283; |
| 3. Б.Нандин-Эрдэнэ | 6,906,074; |
| 4. Такэши Камбэ | 6,909,727; |
| 5. З.Шагдарсүрэн | 6,912,326; |
| <i>б. ТУЗ-ийн ердийн гишүүд</i> | <i>Кумулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо</i> |
| 1. Ц. Баатарсайхан | 7,015,754; |
| 2. Ж.Оюунчимэг | 6,903,528; |
| 3. Хидэо Савада | 6,909,765; |
| 4. Д. Хулан | 6,903,301; |
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоохыг батлах тухай
Зөвшөөрсөн 99.84%, татгалзсан 0.04 %, түдгэлзсэн 0.13%;

Тооллогын комиссын дарга Ч.Солонго, нарийн бичгийн дарга М.Болортуяа, гишүүд Ц.Цэцэгбадам, З.Золжаргал, П.Төгсжаргал.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2017 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн ТУЗ нь тус компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж

болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-ийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

ТУЗ-ийн баталсан 2017 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь түүхий эд бэлтгэлийн ажлыг сайтар зохион байгуулах, гадаад дотоод захиалгыг үйлдвэрлэлтэй нягт хослуулан, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

Говь ХК 2017 онд 124.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 113%, цэвэр ашиг 17.5 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 97%-ийн гүйцэтгэлтэй гарлаа. Говь ХК-ийн гадаад борлуулалт 2017 онд 49.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 44% өсч, 74.6 тэрбум төгрөгийн дотоод борлуулалт хийж өмнөх оноос 38%-ийн өсөлтийг тус тус хангасан байна.

Мөн 2017 онд түүхий эд бэлтгэлийг өмнөх 2016 оноос 54%-иар нэмэгдүүлж, нийт 743 тонн түүхий эд бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нийт 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 7.4 тэрбум төгрөг буюу 69%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 3.3 тэрбум төгрөг буюу 31%-ийг барилгын өргөтгөл, шинэчлэлт болон бусад хөрөнгө оруулалтад зориулсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2017 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

Хоёр. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй.

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт
6.2 ТУЗ		
1	6.2.2 ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн	6.2.2 ТУЗ нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс

	байна.	доошгүй нь хараат бус гишүүн байна.
2	6.2.7.11 ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;	6.2.7.11 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
6.3 Гүйцэтгэх удирдлага		
3	6.3.3.4 Компанийн дотоод журмыг баталж, мөрдүүлэх;	6.3.3.4 Компанийн дотоод журам, үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх;
4	6.3.3.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулах;	6.3.3.6 ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй шууд харилцаж, тэдэнтэй гэрээ, хэлэлцээр байгуулах;
5	6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. Өөрийн ажлын аппаратыг байгуулж, түүний бүтэц, төсвийг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаа явуулах;	6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн бүтэц, орон тоог бие даан баталж мөрдүүлэх;
6	6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоодод мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;	6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоод болон гадаад орнуудад мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;

3. ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтууд, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг удирдлага болгон, 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр:

Мягмарын БАЯР
Дамбын ГЭРЭЛМАА
Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ
Такэши КАМБЭ
Зуунайн Шагдарсүрэн нарыг;

Говь ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН

Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ

Хидэо САВАДА

Дашдаваагийн ХУЛАН нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгосугай.

4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зүгээс оруулсан санал болон 2018 оны 4 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг тогтмол цалин болон гишүүдийн оролцоонд үндэслэсэн оролцооны цалингаас бүрдэхээр тогтоосугай.

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалин болон оролцооны цалингийн хэмжээг Хавсралт 1 ёсоор шинэчлэн тогтоосугай.

Гурав. ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалинг сар бүр, оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн тооцож, улиралд нэг удаа олгосугай.

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ШИНЭЧИЛСЭН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Шинэчилсэн цалин /төг/
Тогтмол цалин	Үндсэн	1,000,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	800,000
	Хорооны даргын нэмэгдэл	300,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	500,000

Хурал 16 цаг 20 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга

Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Сургалт хөгжил, идэвхжүүлэлтийн менежер

Ц.НЯМЦЭЦЭГ